



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 16 өдөр

Дугаар А/105

Арвайхээр сум

**Хөрөнгө зарцуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/03 дугаар тогтоолоор батлагдсан “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг болон хууль сахиулах байгууллагуудад албаны үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, засвар үйлчилгээний зардалд 83,500,000 (наян гурван сая таван зуун мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлж, зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардлыг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0217

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар  
сарын 15-ны өдрийн 01105 дугаар  
захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Байгууллагын нэр	Төсөвт өртөг (мян төг)
1.	Өвөрхангай аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төвд техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах зардал	20,000,000
2.	Хархорин сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-423 дугаар нээлттэй, хаалттай хорих ангид техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах зардал	15,000,000
3.	Аймгийн Цагдаагийн газарт техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах, сургалтын төвийн засварын зардал	18,500,000
4.	Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт техник хэрэгсэл, хамгаалалтын хашаа барих зардал	15,000,000
5.	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн тоног төхөөрөмжийн засвар, шинэчлэлийн зардал	15,000,000
Нийт дүн		83,500,000

-оОо-